



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Гавшгай ус" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/020/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: А.Гэрэлмаа

Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	101
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
4. Аудитын тайлан	14
4.1. Ерөнхий зүйл.....	14
4.2. Материаллаг байдал.....	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.3.1 Шилэн дансны мэдээлэл	15
4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт.....	18
5.1 Залруулга	18
5.2 Албан шаардлага.....	18
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	21



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ГАВШГАЙ УС” ААТҮГ-ЫН
ДАРГА Б.ҮҮРДМӨНХ ТАНАА

2025.03.14 № СЭА-2025/020/НА-СТА-ОНӨҮГ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 20 дугаар зүйлийн 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Боловсруулж, батлуулсан 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг 577,018.7 мянган төгрөгөөр тасалсан,

- НӨАТ төлөгч биш иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авалтыг хийх, нягтлан бодох бүртгэлд НӨАТ салгалгүй бүртгэх зэргээр үнэн зөв тайлагнаагүйгээс татварын өр төлбөр болон алдагдлыг нэмэгдүүлсэн.
- Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 478,344.3 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, шууд худалдан авах босго үнээс давсан шатахуун, харьцуулалтын аргаар худалдан авах босго үнээс давсан нүүрсний худалдан авах ажиллагааг нийтэд ил тод зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй,
- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,
- Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

“Гавшгай ус” ААТҮГ нь тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 252,212.9 мянган төгрөгийн “Номгон цэвэр усны шугам татах”, 184,900.0 мянган төгрөгийн “Малын худгийн усалгааны систем шинээр суурилуулах”, 74,950.9 мянган төгрөгийн “Малын худаг гаргах”, 19,900.0 мянган төгрөгийн гүний худгийн насос зэрэг нийт 531,963.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны орлогыг 2,453,128.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,453,128.9 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,876,110.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,340,354.5 мянган төгрөгийн зардал гарган, 478,344.3 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Гавшгай-ус ” ААТҮГ-ын 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8,790,143.45	1,065,043.02
1.1.2	Дансны авлага	1,691,649,826.59	1,682,639,226.11
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,546,225.90	100,000.00
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.6	Бараа материал	285,239,282.98	234,248,454.83
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	2,800,000.00	2,800,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,992,025,478.92	1,920,852,723.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,747,292,425.14	4,089,480,780.28
1.2.2	Биет бус хөрөнгө	842,264,959.00	838,551,196.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,589,557,384.14	4,928,031,976.28
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,581,582,863.06	6,848,884,700.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	156,866,592.63	139,019,647.49
2.1.1.2	Цалингийн өглөг	24,632,937.86	61,831,149.38
2.1.1.3	Татварын өр	714,971,234.93	806,812,404.41
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,130,049,849.26	1,232,539,664.61
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1,951,200.00	1,951,200.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,028,471,814.68	2,242,154,065.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,028,471,814.68	2,242,154,065.89
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	294,374,941.69	294,374,941.69
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,026,649,071.80	5,026,649,071.80
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,556,423,439.00	2,088,387,300.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,324,336,404.11)	(2,802,680,679.14)
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,553,111,048.38	4,606,730,634.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	6,581,582,863.06	6,848,884,700.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,741,471,932.92	1,873,643,444.55
2	Борлуулалтын өртөг	1,943,964,386.41	2,147,315,980.67
3	Нийт ашиг (алдагдал)	(202,492,453.49)	(273,672,536.12)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	53,008,847.63	2,466,811.65
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	145,673,100.99	163,766,067.55
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	28,685,990.25	43,372,483.01
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(323,842,697.10)	(478,344,275.03)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(323,842,697.10)	(478,344,275.03)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(323,842,697.10)	(478,344,275.03)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(323,842,697.10)	(478,344,275.03)
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,999,708,446.41)	7,147,472,825.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	7,296,382,891.35	1,556,423,439.00	(1,999,708,446.41)	7,147,472,825.63
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
5	Өмчид гаргасан өөрчлөлт	-	(2,269,733,819.55)	-	(785,260.60)	(2,270,519,080.15)
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(323,842,697.10)	(323,842,697.10)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	1,556,423,439.00	(2,324,336,404.11)	4,553,111,048.38
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	1,556,423,439.00	(2,324,336,404.11)	4,553,111,048.38
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	531,963,861.00	-	531,963,861.00
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(478,344,275.03)	(478,344,275.03)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
17	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	294,374,941.69	5,026,649,071.80	2,088,387,300.00	(2,802,680,679.14)	4,606,730,634.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,634,735,761.97	1,864,590,335.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,569,323,378.34	1,862,137,808.20
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	65,357,725.20	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	54,658.43	2,452,527.32
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,701,615,772.07	1,872,315,435.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	629,413,808.51	780,366,155.75
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	72,874,081.00	133,916,220.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	147,012,667.90	320,497,110.56
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	336,892,861.34	357,959,135.84
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	319,542,442.50	141,501,389.93
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	338,395.88	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	127,163,472.51	114,026,994.82
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	68,378,042.43	24,048,429.05
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(66,880,010.10)	(7,725,100.43)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(66,880,010.10)	(7,725,100.43)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	75,670,153.55	8,790,143.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,790,143.45	1,065,043.02

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Нийт орлого /НӨАТ-гүй/	м/төг	2,453,128.9	1,876,110.3	(577,018.7)	(0.2)
	Үйл ажиллагааны орлого	м/төг	1,917,128.9	1,412,117.9	(505,011.0)	(0.3)
	Дулааны борлуулалт /Номгон/	м/төг	247,000.0	219,848.1	(27,151.9)	(0.1)
	Татаас санхүүжилтийн орлого	м/төг			-	
	Бусад орлого	м/төг	289,000.0	244,144.3	(44,855.7)	(0.2)
2	Нийт зарлагын дүн	м/төг	2,433,128.9	2,340,354.5	(92,774.4)	(0.0)
3	Цалин хөлс	м/төг	1,254,000.0	990,655.6	(263,344.4)	(0.2)
4	НДШ-ийн зардал	м/төг	-	155,568.9	155,568.9	
5	Бараа үйлчилгээний бусад зардал	м/төг	1,179,128.9	1,194,130.0	15,001.1	0.0
	Цахилгаан	м/төг	400,000.0	315,763.0	(84,237.0)	(0.2)
	Дулаан	м/төг	54,000.0	42,447.0	(11,553.0)	(0.2)
	Нүүрс	м/төг	108,000.0	103,164.9	(4,835.1)	(0.0)
	Түлш, шатахуун	м/төг	52,756.9	43,640.9	(9,116.0)	(0.2)
	Сэлбэг, материал	м/төг	63,500.0	-	(63,500.0)	(1.0)
	Засвар үйлчилгээний зардал	м/төг	220,321.0	215,215.1	(5,105.9)	(0.0)
	Бичиг хэрэг	м/төг	3,000.0	3,286.0	286.0	0.1
	Албан томилолт	м/төг	10,000.0	4,464.0	(5,536.0)	(0.6)
	Хөдөлмөр хамгаалал, ариутгал халдаргүйжүүлэлт	м/төг	35,451.0	9,565.8	(25,885.2)	(0.7)
	Лабораторийн зардал	м/төг	4,000.0	6,862.2	2,862.2	0.7
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	м/төг	185,000.0	325,207.5	140,207.5	0.8
	Хангамжийн материалын элэгдлийн зардал	м/төг		25,623.7	25,623.7	
	Шуудан холбооны зардал	м/төг	4,400.0	4,862.3	462.3	0.1
	Түрээсийн зардал	м/төг		150.0	150.0	
	Тээврийн зардал	м/төг		3,127.0	3,127.0	
	Сургалт	м/төг	8,700.0	1,015.0	(7,685.0)	(0.9)
	НӨАТ, ХХОАТ, Суутган	м/төг		-	-	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	м/төг	28,000.0	41,822.1	13,822.1	0.5
	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	м/төг		18,324.4	18,324.4	
Даатгалын зардал	м/төг	2,000.0	-	(2,000.0)	(1.0)	
Бусад зардал	м/төг		29,589.3	29,589.3		
6	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	м/төг	20,000.0	(464,244.3)	(484,244.3)	(24.2)
7	Орлогын албан татвар	м/төг			-	
8	Үйл ажиллагааны бус зардал	м/төг	20,000.0	14,100.0	(5,900.0)	(0.3)
	Үйл ажиллагааны бус бусад зардал	м/төг	5,000.0	3,100.0	(1,900.0)	(0.4)
	Ажиллагсадын нийгмийн зардал	м/төг	15,000.0	11,000.0	(4,000.0)	(0.3)
9	Татварын дараахь ашиг, алдагдал	м/төг	0.0	(478,344.3)	(478,344.3)	
10	Хөрөнгө оруулалт	м/төг	-	-	-	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Гавшгай ус” ААТҮГ нь *“Хөтөл тосгоны ард иргэд, аж ахуйн нэгжийг унд, ахуйн цэвэр усаар тасралтгүй, найдвартай хангах”* гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Гавшгай ус” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Усан хангамж, ариутгах татуурга,
- Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил,
- Барилга байгууламжийн засвар үйлчилгээ, гражийн барилга байгууламж,
- Усны хайгуул, судалгаа,
- Халуун ус, саун,
- Номгон тосгоны уурын зуух,
- Гадаад худалдаа гэх мэт.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал буюу төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймгийн Засаг дарга байх бөгөөд 100 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Гавшгай Ус” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2005 оны 78 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 80 дугаар тогтоолоор “Гавшгай Ус” ААТҮГ болон өөрчлөгдсөн байна.

Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-д *“Аймаг, сум, нийслэл, дүүрэг нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулж болно”*, 21 дүгээр зүйл *“Аймгийн чиг үүрэг”*, 21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь *“харилцаа холбоо, цахилгаан, дулаан түгээх сүлжээ, цэвэр ус, бохир усны шугам болон хаягдал ус зайлуулах байгууламж, үерийн далан, суваг тэдгээрт хамааралтай барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалт, хяналт”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д *“Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих”* гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагад Төлөөлөн удирдах зөвлөл байхгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Нийгмийн даатгалын ерөнхий хууль*

- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05, 08 дугаар сарын 30-нд нэмэлт өөрчлөлт орсон, гэх мэт.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Гавшгай ус” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц гэж үнэлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь захирлын 2022 оны 08 сарын 25-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Гавшгай ус” ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,790.2	1,065.0	(7,725.2)
Авлага	1,691,649.8	1,682,639.2	(9,010.6)
Татвар, НДШ-ийн авлага	3,546.2	100.0	(3,446.2)
Бараа материал	285,239.3	234,248.5	(50,990.8)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,800.0	2,800.0	-
Үндсэн хөрөнгө	4,589,557.3	4,928,032.0	338,474.7
Нийт хөрөнгийн дүн	6,581,582.8	6,848,884.7	267,301.9
Өр төлбөр	2,028,471.8	2,242,154.0	213,682.2

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,026,649.1	5,026,649.1	-
Эздийн өмч	(473,538.1)	(419,918.4)	53,619.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,581,582.8	6,848,884.7	267,301.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,725.2 мянган төгрөгөөр буурсан нь 1,864,590.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,872,315.4 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Дансны авлага 1,682,639.2 мянган төгрөг болж 9,010.6 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн нэгжээс авах үйлчилгээний төлбөрийн авлага буурснаас голлон шалтгаалсан байна.

Нийт авлагын 56.9 хувийг буюу 959,623.2 мянган төгрөгийг оршин суугчдаас авах усны, 37.8 хувийг буюу 637,559.8 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжээс авах усны, 4.1 хувийг буюу 68,436.3 мянган төгрөгийг ажиллагсдаас авах, 1.2 хувийг буюу 19,819.9 мянган төгрөгийг хувь хүнээс авах авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй ажиллагсдаас *ажлаас гарсан* авах 51,814.8 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 19,819.9 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 234,248.5 мянган төгрөг болж 50,990.8 мянган төгрөгөөр буурсан нь 381,447.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 432,438.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,928,032.0 мянган төгрөг болж 338,474.7 мянган төгрөгөөр өссөн нь өөрийн хөрөнгөөр 131,718.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 252,212.9 мянган төгрөгийн “Номгон цэвэр усны шугам татах”, 184,900.0 мянган төгрөгийн “Малын худгийн усалгааны систем шинээр суурилуулах”, 74,950.9 мянган төгрөгийн “Малын худаг гаргах”, 19,900.0 мянган төгрөгийн гүний худгийн насос зэрэг нийт 531,963.8 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, 325,207.4 мянган төгрөгийн элэгдэл тооцсоноос шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,242,154.0 мянган төгрөг болж 213,682.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

Нийт өр төлбөрийн 55.0 хувийг буюу 1,232,539.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн, 36.0 хувийг буюу 807,009.7 мянган төгрөгийг татварын, 6.3 хувийг буюу 140,773.5 мянган төгрөгийг дансны өр төлбөр, 2.8 хувийг буюу 61,831.1 мянган төгрөгийг цалингийн өр төлбөр эзэлж байна.

Дансны өр төлбөрийн 80.7 хувийг буюу 113,587.7 мянган төгрөгийг байгууллага, аж ахуйн нэгжид өгөх бараа үйлчилгээний, 12.9 хувийг буюу 18,157.9 мянган төгрөгийг хувь хүмүүст өгөх, 3.7 хувийг буюу 5,140.6 мянган төгрөгийг ажиллагсдад өгөх, 1.5 хувийг буюу 2,133.5 мянган төгрөгийг оршин суугчдад өгөх, 1.2 хувийг буюу 1,753.9 мянган төгрөгийг үйлдвэрчний эвлэлийн татварын өр төлбөр тус тус эзэлж байна.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. “Гавшгай ус” ААТҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж Сэлэнгэ аймгийн Засаг даргаар батлуулсан байна.

Тайлант оны орлогыг 2,453,128.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 2,453,128.9 мянган төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлээр 1,876,110.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,340,354.5 мянган төгрөгийн зардал гарган, 478,344.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого 1,876,110.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөгөөг 50.7 хувиар тасарсан нь үнэ тарифт өөрчлөлт оруулахаар орлогыг нэмэгдүүлэн төлөвлөснөөс *12021 оноос хойш үнэ тарифт өөрчлөлт ороогүй, ижил төстэй байгууллагатай харьцуулахад цэвэр, бохир усны нэгж үнэ дунджаар литр тутамд 0.4-1.2 төгрөгөөр бага, зах зээл дээрхи үнийн өсөлтөөс хамаарч зардал нэмэгдсэн* буюу гол харилцагч болох Цемент шохой компанид нийлүүлж буй борлуулалтаас голлон шалтгаалсан байна.

Нийт зардал 2,340,354.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнагдан, төлөвлөсөн зардлыг 4.5 хувиар буюу 92,744.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь цахилгаан, дулаан, шатахууны зардлыг хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Гавшгай ус” ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн авлага, өр төлбөрийг бууруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, татварын бүртгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Гавшгай ус” ААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,118,323.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,774.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлд тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тайлант хугацаанд “Гавшгай ус” ААТҮГ нь мэдээлбэл зохих 26 төрлийн 157 мэдээллээс 15 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроож мэдээлсэн:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт - 12 удаа,
- Санхүүгийн тайлан - 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – 1 удаа,

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан - 1 удаа,

Огт мэдээлээгүй:

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг - 1 удаа,
- Байгууллагын батлагдсан төсөв - 1 удаа гэх мэт.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Үнийн харьцуулалт хийлгүйгээр шууд худалдан авах босго үнээс давсан 43,333.7 мянган төгрөгийн шатахууныг “Тэс петролиум” ХХК-тай, харьцуулалтын аргын босго үнээс давсан 113,556.4 мянган төгрөгийн нүүрсний худалдан авалтыг авлагадаа суутгуулан тооцдог гэх шалтгаанаар “Хөтөл энерги дулаан” ХХК-тай тус тус шууд гэрээ байгуулж гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар- Бараа-20.0 сая төгрөг” 2: “Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн

заалтын дагуу дарга Б.Үүрдмөнх-д сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Гавшгай ус” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цахилгааны зардлыг 84,237.0 мянган төгрөгөөр,
- Дулааны зардлыг 11,553.0 мянган төгрөгөөр,
- Шатахууны зардлыг 9,116.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэн,
- Хандив тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргаагүй, өөрийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглох зэргээр хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбарын 2024 оны 11 дүгээр 19-ний өдрийн 24/63 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2024 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 398,777.0 мянган төгрөгийн зөрчил илэрч, 334,363.1 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, шилэн данс болон худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 40.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	334,363.1	2	334,363.1	66.6
Зөвлөмж	2	64,413.9	-	-	
Нийт дүн	5	398,777.0	2	334,363.1	40.0

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. Аудитын илрүүлэлт :

5.1 Залруулсан алдаа:

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой нийт **630,075.6** мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 531,963.9 мянган төгрөгийн малын худаг болон цэвэр усны шугамын ажлыг орлогын дэлгэрэнгүй тайлан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд бусад борлуулалтаар тайлагнан татвар ногдуулсан,
- Үл хөдлөх эд хөрөнгийн 3,546.2 мянган төгрөгийн, газрын төлбөрийн 228.9 мянган төгрөгийн татварыг ногдуулж тайлагнаагүй,
- Санхүүгийн байдлын тайлангийн НӨАТ-н үлдэгдэл татварын үлдэгдлээс 50,448.9 мянган төгрөгөөр илүү тайлагнагдсан,
- Орлогын дэлгэрэнгүй тайланд цахилгааны зардлыг НӨАТ салгалгүй тайлагнаснаас 30,109.3 мянган төгрөгөөр, хугацаа хэтэрсэн алдангийн 13,778.4 мянган төгрөгийн дансны бичилтийг буруу хийсэн зэргээс нийт 43,887.7 мянган төгрөгөөр зардал илүү тайлагнасан гэх мэт.

Аудитаар нийт **637,252.4** мянган төгрөгийн 6 зөрчил¹ илрүүлснээс 633,462.8 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 3,789.6 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 39,311.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь “*Зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх*” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулсны үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Боловсруулж, батлуулсан 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тайлант онд бүтээгдэхүүний үнэ тарифт өөрчлөлт оруулах замаар орлогыг нэмэгдүүлж, 2,453,128.9 мянган төгрөг байхаар төлөвлөсөн боловч үнэ тарифт өөрчлөлт ороогүйгээс 1,876,110.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг **577,018.7** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**" гэсэн заалт болон аймгийн Засаг даргын баталсан "Гавшгай ус" ААТҮГ-ын 2024 оны санхүүгийн орлого, зарлагын нэгдсэн төлөвлөгөө" -г тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг бодитой төлөвлөж, батлуулах, үнэ тарифт өөрчлөлт оруулах талаарх асуудлыг холбогдох байгууллагад танилцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулан НӨАТ төлөгч биш иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авалтыг хийх, нягтлан бодох бүртгэлд НӨАТ салгалгүй бүртгэх зэргээр үнэн зөв тайлагнахгүй байгаа нь татварын өр төлбөр болон алдагдлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Тухайлбал:

- Тайлант онд 137,810.7 мянган төгрөгийн бараа материал, 50,650.9 мянган төгрөгийн ажил үйлчилгээг НӨАТ төлөгч биш харилцагчаас авснаар **17,132.9** мянган төгрөгийн НӨАТ-ын өр төлбөр буюу алдагдлыг нэмэгдүүлсэн,
- Тайлан гарахаас өмнө тооцоо нийлж баталгаажуулдаггүй, дансны бичилтийг буруу хийсэн, НӨАТ салгаж бүртгээгүй зэргээс 50,448.9 мянган төгрөгийн НӨАТ-ын өр төлбөр илүү тайлагнагдаж, зардал өссөн зэргээр алдагдал болон татварын өр төлбөр өссөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг НӨАТ төлөгч иргэн, аж ахуйн нэгжээс авч НӨАТ-ын өр төлбөрийг бууруулж ажиллах, анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Хуримтлагдсан ашиг, алдагдал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд үйл ажиллагааны үр дүнгээр 478,344.3 мянган төгрөгийн алдагдал хүлээж, өөрийгөө санхүүжүүлж чадаагүй бөгөөд үйл ажиллагаа явуулах тусам алдагдлын хэмжээ нэмэгдэж байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэнэ.....*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Тус газрын үйл ажиллагаанд санхүүгийн шинжилгээ хийж, өөрийгөө санхүүжүүлэн ажиллах.

2. Авлага, өр төлбөрийн үлдэгдэлтэй холбоотой

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 1,685,439.2 мянган төгрөгийн авлага, 2,242,154.1 мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна. Авлага, өр төлбөрийг үр дүнд нөлөөлөхүйцээр барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжүүлээгүйгээс он дамжсан авлага, өр төлбөр тайлагнагдаж, төлбөрийн чадвар, эдийн засгийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж, байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлага, өр төлбөрт дүн шинжилгээ хийж бууруулах үр нөлөө бүхий арга хэмжээ авах.

3. Цалин хөлс болон татварын тайлагналтай холбоотой

3.1 Илрүүлэлт: Цалин, хөлснөөс ХХОАТ-ыг суутган тооцохдоо хууль журмыг баримталдаггүй, татварт үнэн зөв тайлагнадаггүйгээс нийт 3,789.6 мянган төгрөгөөр ХХОАТ-ыг илүү тайлагнасан дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ХХОАТ-ыг чөлөөлөхгүйгээр татвар ногдуулан боддог,
- ХХОАТ-ын тайланд 13,884.5 мянган төгрөгийн хөнгөлөлтийг хасаж тооцоогүй,
- ХХОАТ-ын тайланд тэтгэвэрт гараад ажиллаж буй ажиллагсдын 10,095.0 мянган төгрөгийн татварыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр тайлагнан татварыг ногдуулаагүй,

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 “*хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого*”, 23 дугаар зүйлийн 23.1 “*Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ*” – гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ыг анхан шатны баримтыг үндэслэн үнэн зөв суутган тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Үл хөдлөх эд хөрөнгийн татварыг ногдуулж тайлагнаагүй.	1	3,775.1	1	3,775.1			1	3,775.1				
ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн малын худаг болон цэвэр усны шугамын ажлыг орлогын дэлгэрэнгүй тайлан, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд бусад борлуулалтаар тайлагнан татвар ногдуулсан.	1	531,963.9			1	531,963.9	1	531,963.9				
Санхүүгийн байдлын тайлангийн НӨАТ-н үлдэгдэл татварын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан	1	50,448.9			1	50,448.9	1	50,448.9				
Зардал илүү тайлагнасан	1	43,887.7			1	43,887.7	1	43,887.7				
Дүн	4	630,075.6	1	3,775.1	3	626,300.5	4	630,075.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	39,311.2			1	39,311.2						
Санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан орлогын төлөвлөгөөг тасалсан	1	577,018.7			1	577,018.7						
Шууд худалдан авалтыг ихэвчлэн НӨАТ төлөгч биш иргэн, аж ахуйн нэгжээс худалдан авалтыг хийснээр татварын өр төлбөр болон алдагдлыг нэмэгдүүлсэн	1	17,132.9			1	17,132.9						
Өөрөө өөрийгөө санхүүжүүлж ажиллаж чадаагүй	1	-					1	-				
Авлага бууруулах талаар төлөвлөгөө гарган ажиллаагүй	1	-					1	-				
ХХОАТ-ын тайланд татвар илүү тайлагнасан.	1	3,789.6					1	3,789.6				
Дүн	6	637,252.4			3	633,462.8	3	3,789.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны мэдээллийг 15 удаа хоцроосон, 2 мэдээллийг огт мэдээлээгүй	1				1					
Дүн	1				1					
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	-							1	-
Дүн	1	-							1	-
Нийт дүн	2				1	-			1	-